Ёс зүйн хорооны 2025 оны ... дугаар
сарын ...-ний өдрийн ... дугаар тогтоолын
нэгдүгээр хавсралт

ТӨМӨР ЗАМЫН ГАЗРЫН 2025 ОНЫ
“ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ”

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо[1]	Хувийн жин[2]
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн батлуулсан эсэх[4]		1	1	10
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1	0	0
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0,5	0.5	5
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0,5	0.5	5
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]	0,5	0	0
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9]	0,5	0	0
Хэсгийн оноо				**4**	**2**	**20**
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] (*гарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)*		1	1	10
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11]		1	0	0
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]		1	1	10
Хэсгийн оноо				**3**	**2**	**20**
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]		1	1	10
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] *(Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)*		1	0.5	5
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]		1	0	0
Хэсгийн оноо				**3**	**1.5**	**15**
Үнэлгээний нийт оноо, хувь				**10**	**5.5**	**55**

$$\text{Эзлэх хувь} = \frac{\text{ҮХХ} + \text{ЁЗМ} + \text{ЁЗДХ}}{10} * 100\%$$

Тайлбар:
[1] Байгууллагын өөрийн болон харьяа, салбар байгууллагад өгсөн үнэлгээ.
[2] Авсан оноог 10-аар үржиж хувийн жинг тооцох ба нийт дүн 100-с хэтрэхгүй байна.
[3] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”.
[4] ЁЗХ-ны 2025 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт”-д нийцүүлэн батлагдсан төлөвлөгөөг хавсарган ирүүлнэ.
[5] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар "Аргачлал батлах тухай" тогтоол.
[6] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 2.1 дэх хэсэг, ЁЗХ-ны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 4.1.3, мөн оны 15 дугаар “Сургалтын агуулга, сэдэв батлах тухай” тогтоол.
[7] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт.
[8] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал”-ын 8.3.3, мөн оны 07 дугаар "Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах, шалган шийдвэрлэх талаар авах арга хэмжээний тухай" тогтоол.
[9]ЁЗХ-ны 2024 оны 13 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-ын 3.8 дахь хэсэг, 2025 оны 08 дугаар "Загвар батлах тухай" тогтоол.
[10] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт.
[11] Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг.
[12] Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт.
[13] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-ын 4.2.2 дахь заалт.
[14] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1 дэх заалт.
[15] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-ын 4.4.3, 4.4.4 дэх заалт.

-oOo-

БАТЛАВ
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА

Д.ЖАВХЛАН

ТӨМӨР ЗАМЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Зорилтот түвшин	Хугацаа	Хариуцах албан тушаалтан, нэгж	Хамтран хэрэгжүүлэх байгууллага, нэгж
1	Зам, тээврийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хорооноос ирүүлсэн дүгнэлт, шийдвэр, зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулах	Дүгнэлт, шийдвэр, зөвлөмж ирсэн эсэх	Тоо	Тухай бүр	Жилийн турш	ЗУГ	Ёс зүйн хороо, ЗТЯ-ны дэргэдэх Ёс зүйн дэд хороо
2	Ёс зүйн хороо, Зам, тээврийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулах арга хэмжээнүүдэд оролцох.	Арга хэмжээ зохион байгуулагдсан эсэх	Тоо	Тухай бүр	Жилийн турш	ЗУГ	Ёс зүйн хороо, ЗТЯ-ны дэргэдэх Ёс зүйн дэд хороо
3	Төрийн албан хаагчийн ёс зүйн талаарх мэдлэг олгох сургалтыг зохион байгуулах.	Сургалт зохион байгуулах	Тоо	Тухай бүр	Жилийн турш	ЗУГ	Ёс зүйн хороо, ЗТЯ-ны дэргэдэх Ёс зүйн дэд хороо
4	Ёс зүйн талаар хийгдсэн сургалт, семинар, хэлэлцүүлэгт хамрагдсан байх.	Арга хэмжээ зохион байгуулагдсан эсэх	Тоо	Тухай бүр	Жилийн турш	ЗУГ	Ёс зүйн хороо, ЗТЯ-ны дэргэдэх Ёс зүйн дэд хороо

Боловсруулсан:
Ёс зүйн дэд хорооны нарийн бичиг Ц.Цэнгэлмаа

ТӨМӨР ЗАМЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Зорилтот түвшин	Хугацаа	Биелэлт
1	Зам, тээврийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хорооноос ирүүлсэн дүгнэлт, шийдвэр, зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулах	Дүгнэлт, шийдвэр, зөвлөмж ирсэн эсэх	Тоо	Тухай бүр	Жилийн турш	Зам, тээврийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хорооноос дүгнэлт, шийдвэр, зөвлөмж ирүүлээгүй.
2	Ёс зүйн хороо, Зам, тээврийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулах арга хэмжээнүүдэд оролцох.	Арга хэмжээ зохион байгуулагдсан эсэх	Тоо	Тухай бүр	Жилийн турш	Удирдлагын академийн Төрийн албаны сургууль, Ёс зүйн хороо хамтран 2025 оны 12 дугаар сард зохион байгуулсан “Ёс зүй, хүний эрх” сэдэвт сургалт, хэлэлцүүлэгт Төмөр замын газрын дарга, Захиргаа удирдлагын газрын дарга нар хамрагдсан.
3	Төрийн албан хаагчийн ёс зүйн талаарх мэдлэг олгох сургалтыг зохион байгуулах.	Сургалт зохион байгуулах	Тоо	Тухай бүр	Жилийн турш	Зам, тээврийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороотой хамтран 2025.06.18-ны өдөр шинээр томилогдсон албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай мэдлэг олгох сургалт зохион байгуулсан. Мөн 2025.12.12-ны өдөр Зам, тээврийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороотой хамтран нийт албан хаагчдад мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан.
4	Ёс зүйн талаар хийгдсэн сургалт, семинар, хэлэлцүүлэгт хамрагдсан байх.	Арга хэмжээ зохион байгуулагдсан эсэх	Тоо	Тухай бүр	Жилийн турш	Удирдлагын академийн Төрийн албаны сургууль, Ёс зүйн хороо хамтран зохион байгуулсан “Ёс зүй, хүний эрх” сэдэвт 16 цагийн сургалтад 2025.11.13-14-ний өдрүүдэд Ц.Цэнгэлмаа, 2025.11.27-28-ны өдрүүдэд Э.Осоржамаа нар хамрагдсан.

Биелэлт гаргасан:
Ёс зүйн дэд хорооны нарийн бичиг Ц.Цэнгэлмаа

Хянасан:
Ёс зүйн дэд хорооны дарга Д.Жавхлан

ТӨМӨР ЗАМЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
“ТАЙЛАНГИЙН МАЯГТ”[1]

НЭГ. Товч танилцуулга[2]
Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон Ёс зүйн хорооны баталсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-д заасны дагуу Төмөр замын газрын дэргэдэх “Ёс зүйн дэд хороо”-г Төмөр замын газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн “Ёс зүйн дэд хороо байгуулах тухай” А/32 дугаар тушаалаар байгуулсан. Төмөр замын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэхээр хурлын төлөвлөгөөг батлуулан 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдөр дэд хорооны 01 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн, батлуулж, төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагааг заасан хугацаанд хэрэгжүүлж, Ёс зүйн зөрчил, гомдлыг хүлээн авч холбогдох хариуг хүргүүлэн ажиллаж байна.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3]:
Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон Ёс зүйн хорооны баталсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-д заасны дагуу Төмөр замын газрын дэргэдэх “Ёс зүйн дэд хороо”-г Төмөр замын газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн “Ёс зүйн дэд хороо байгуулах тухай” А/32 дугаар тушаалаар байгуулсан. Төмөр замын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэхээр хурлын төлөвлөгөөг батлуулан 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдөр дэд хорооны 01 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн, батлуулж, төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагааг заасан хугацаанд хэрэгжүүлж, Ёс зүйн зөрчил, гомдлыг хүлээн авч холбогдох хариуг хүргүүлэн ажиллаж байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг сурталчлах ажлыг агентлагийн хэмжээнд зохион байгуулсан. Зам, тээврийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороотой хамтран шинээр томилогдсон албан хаагчдад “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтыг 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан. Удирдлагын академийн Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны 40 цагийн сургалтад 2025 оны 10 болон 12 дугаар сард анх томилогдсон нийт 8 албан хаагчийг хамруулсан. Мөн Зам, тээврийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороотой хамтран Төрийн албаны тухай, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай сургалтыг 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулж агентлагийн нийт 23 албан хаагчийг хамруулсан.

[1] Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үр дүнг нэгтгэн ирүүлнэ.

[2] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.

[3] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

Удирдлагын академийн Төрийн албаны сургууль, Ёс зүйн хороо хамтран 2025 оны 11, 12 дугаар сард зохион байгуулсан “Ёс зүй, хүний эрх” сэдэвт 16 цагийн сургалтад Ёс зүйн дэд хорооны гишүүд хамрагдсан.

Байгууллагын ёс зүй, хүний эрх, хувь хүний соёлтой холбоотой “Технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэхэд нэгдье” аяны арга хэмжээг 2025 оны 12 дугаар сард агентлагийн хэмжээнд зохион байгуулсан.

2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Удирдлагын академийн Төрийн албаны сургууль, Ёс зүйн хороо хамтран 2025 оны 12 дугаар сард зохион байгуулсан “Ёс зүй, хүний эрх” сэдэвт сургалт, хэлэлцүүлэгт Төмөр замын газрын дарга хамрагдсан.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

Зам, тээврийн яамны 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 05/3936 тоот албан бичгээр ирүүлсэн “Монгол Улсын Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв”-д иргэнээс тус агентлагын албан хаагчид хандаж гаргасан гомдлыг Төмөр замын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдаанаар авч хэлэлцсэн. Ёс зүйн дэд хороо тус гомдол, мэдээллийг хянан шалгаад албаны бус хувийн шугамаар мэдээлэл аван холбогдохдоо буруу ойлголцсон тул ёс зүйн зөрчил гаргаагүй гэж үзэн 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 01 дүгээр дүгнэлт гарган 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 02/291 тоот албан бичгээр Зам, тээврийн яаманд хүргүүлж ажилласан.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
Төмөр замын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны нарийн бичиг Монгол Улсын Ёс зүйн хороо, Удирдлагын академи хамтран зохион байгуулсан Ёс зүйн сургагч багш бэлтгэх нийт 32 цагийн хөтөлбөрт хамрагдан төгсөж 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн №251436 тоот үнэмлэх авсан тул Зам, тээврийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороотой хамтран сургалт, мэдээлэл зохион байгуулахад хялбар байсан.	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төмөр замын газар нь 2025 онд шинээр байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаатай холбогдуулан Ёс зүйн дэд хороо мөн шинээр байгуулагдсан бөгөөд төлөвлөгөө боловсруулах, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт тайлан мэдээ бэлтгэх зэрэг дээр мэдээлэл дутмаг байлаа.

Санал:

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулах тухай заалттай холбогдуулан цахим санд бүртгүүлэх хүсэлтээ Ёс зүйн хороонд мэдэгдсэн байгаа.

Шалгах хэсэг:

- ☐ “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ☐ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ☐ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан
Төмөр замын газрын дарга
/Албан тушаал/

/Гарын үсэг/

Б.Артур
/Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны дарга
Захиргаа, удирдлагын газрын дарга
/Албан тушаал/ */Гарын үсэг/* Д.Жавхлан
/Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга
Хүний нөөц, сургалт хариуцсан
Ахлах мэргэжилтэн
/Албан тушаал/ */Гарын үсэг/* Ц.Цэнгэлмаа
/Гарын үсгийн тайлал/

Огноо: 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдөр